



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

“Мандал женерал даатгал” ХХК-д
даатгалын зарим хэлбэрээр үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.23, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 356 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мандал женерал даатгал” ХХК-д санхүүгийн даатгал /1.11/, зээлийн даатгалын /1.12/, итгэлцлийн даатгалын /1.13/, төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал /1.14/, төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал /1.15/, агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгалын /1.16/ хэлбэрээр тус тус ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нэмж олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавьж, “Мандал женерал даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэрийг нэмж бүртгэн, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



000328